

“ХААН СОЁМБО АУДИТ” - ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2026/014/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Х.Энхтуяа
Утас: 89182456 Цахим хаяг: enkhtuyakh@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Ахлах аудитор: Г.Заяа
Утас: 95648028, 98828028
Цахим хаяг: zaya96884510@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/245
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
УЛААН-УУЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ А.НАНСАЛМАА
ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд улсын төсвөөс олгох санхүүжилтийг 88,820.3 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэнтэй холбоотойгоор 56,258.9 мянган төгрөгийн бараа үйлчилгээний зардлын өглөг үүссэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 33,887.9 мянган төгрөгийн, төсвийн зарцуулалттай холбоотой 18,936.0 мянган төгрөгийн, цалин олголттой холбоотой 5,740.8 мянган төгрөгийн зөрчил илэрч холбогдох шийдвэрийг гаргасан болно.

Бусад асуудлын хэсэг

Улаан-Уул сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 30 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 92 хувьтай тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

<i>Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлан</i>		<i>/төгрөгөөр/</i>	
Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	324,290,930.50	295,927,254.24	
МӨНГӨН ХӨРӨНГӨ	99,382,196.27	44,990,659.84	
Банкинд байгаа бэлэн мөнгө	99,382,196.27	44,990,659.84	
Төгрөг	99,382,196.27	44,990,659.84	
Төрийн сангийн харилцах	99,382,196.27	44,990,659.84	
АВЛАГА	8,786,250.08	8,786,250.08	
Ажиллагчидтай холбогдсон авлага	4,400,000.00	4,400,000.00	
Бусад авлага	4,386,250.08	4,386,250.08	
Байгууллагаас авах авлага	4,386,250.08	4,386,250.08	
БАРАА МАТЕРИАЛ	216,122,484.15	242,150,344.32	
Түүхий эд материал	3,641,002.00	3,641,002.00	
Тусгай зориулалттай материал	3,641,002.00	3,641,002.00	
Бэлэн бүтээгдэхүүн	6,351,960.00	19,502,740.00	
Хангамжийн материал	195,509,522.15	208,356,602.32	
Бичиг хэргийн материал	1,333,400.00	340,000.00	
Аж ахуйн материал	144,606,272.74	151,269,472.74	
Түлш, шатах тослох материал	8,224,450.05	0.05	
Барилгын засварын материалбь		5,681,400.00	
Хүнсний материал	16,864,948.23	5,184,400.00	
Бусад хангамжийн материал	24,480,451.13	45,881,329.53	
Мал амьтад	10,620,000.00	10,650,000.00	
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,697,178,620.65	1,726,511,693.77	
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,697,178,620.65	1,726,511,693.77	
Биет хөрөнгө	1,697,178,620.65	1,631,093,693.77	
Барилга, байгууламж, орон сууц	1,251,610,909.35	1,251,610,909.35	
Хуримтлагдсан элэгдэл	-432,657,773.89	-459,376,035.37	
Авто-тээврийн хэрэгсэл	32,370,000.00	32,370,000.00	
Хуримтлагдсан элэгдэл	-16,200,000.00	-19,437,000.00	
Машин тоног төхөөрөмж (компьютер)	818,366,674.64	941,531,098.64	
Хуримтлагдсан элэгдэл	-322,822,555.76	-453,824,952.26	
Тавилга, аж ахуйн эд хогшил	268,445,447.99	362,891,187.39	
Хуримтлагдсан элэгдэл	-123,880,542.24	-146,318,788.30	
Бусад үндсэн хөрөнгө	86,765,578.00	86,765,578.00	
Хуримтлагдсан элэгдэл	-32,631,960.60	-37,513,146.84	
Номын фонд	72,394,843.16	72,394,843.16	
Биет бус хөрөнгө	95,418,000.00	95,418,000.00	
Програм хангамж	1,037,000.00	1,037,000.00	
Хуримтлагдсан элэгдэл	-1,037,000.00	-1,037,000.00	
Бусад биет бус хөрөнгө	95,418,000.00	95,418,000.00	
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,021,469,551.15	2,022,438,948.01	
НИЙТ ӨР ТӨЛБӨР	158,446,986.85	145,157,959.36	
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	54,110,890.85	60,160,511.36	
Өглөг	54,110,890.85	60,160,511.36	
Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,822,200.00	53,461,011.29	
Ажиллагчидтай холбогдсон өглөг	6,154,995.85	1,276,200.07	

Бусад өглөг	46,133,695.00	5,423,300.00
Байгууллагад төлөх өглөг	46,133,695.00	5,423,300.00
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	104,336,096.00	84,997,448.00
Урт хугацаат зээл	104,336,096.00	84,997,448.00
Төгрөг	104,336,096.00	84,997,448.00
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	104,336,096.00	84,997,448.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,863,022,564.30	1,877,280,988.65
Засгийн газрын хувь оролцоо	1,863,022,564.30	1,877,280,988.65
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	282,116,816.00	282,116,816.00
Өмч: - төрийн	282,116,816.00	282,116,816.00
Хуримтлагдсан үр дүн	1,196,456,042.41	1,210,714,466.76
Өмнөх үеийн үр дүн	1,196,456,042.41	1,196,456,042.41
Тайлант үеийн үр дүн	00.00	14,258,424.35
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	384,449,705.89	384,449,705.89
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,021,469,551.15	2,022,438,948.01

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,632,683,566.10	4,374,526,081.80
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	162,964,466.10	204,645,781.80
Нийтлэг татварын бус орлого	162,964,466.10	204,645,781.80
Төсөвт байгууллагын өөрийн орлого	7,679,900.00	10,289,200.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,469,900.00	9,299,200.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	210,000.00	990,000.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө	147,786,970.10	188,580,463.40
Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-бараа материал	7,497,596.00	5,776,118.40
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,469,719,100.00	4,169,880,300.00
Улсын төвлөрсөн төсвөөс	3,337,719,100.00	4,014,047,500.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,337,719,100.00	4,014,047,500.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	132,000,000.00	155,832,800.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага	132,000,000.00	155,832,800.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	3,631,460,888.59	4,360,267,657.45
УРСГАЛ ЗАРДАЛ	3,631,460,888.59	4,360,267,657.45
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,509,584,597.90	4,207,025,377.45
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,586,222,355.70	3,144,904,090.11
Цалин	1,625,585,287.16	1,779,743,390.83
Нэмэгдэл цалин	841,877,318.39	1,105,536,738.08
Унаа хоолны хөнгөлөлт	-	101,240,000.00
Урамшуулал	118,759,750.15	158,383,961.20
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	321,323,806.15	385,349,400.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	219,406,994.65	262,037,576.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	25,639,687.53	30,827,756.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	12,847,400.00	15,414,028.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	12,685,944.82	15,414,028.00

Эрүүл мэндийн даатгалын хураамж	50,743,779.15	61,656,012.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	130,554,899.13	154,958,861.29
Гэрэл цахилгааны зардал	17,943,659.87	34,864,911.29
Түлш, халаалтын зардал	109,024,049.95	119,593,950.00
Цэвэр, бохир усны зардал	3,587,189.31	500,000.00
Хангамж, бараа материалын зардал	12,901,250.00	41,026,600.00
Бичиг хэргийн материал	232,000.00	22,780,200.00
Тээвэр, шатахууны зардал	12,669,250.00	12,103,600.00
Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	0,00	6,142,800.00
Нормативт зардал	143,119,110.00	175,528,748.23
Эм	511,000.00	586,600.00
Хоол	142,608,110.00	174,942,148.23
Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	0.00
Эд хогшил, урсгал засварын зардал	12,191,200.00	47,714,940.00
Урсгал засвар	12,191,200.00	47,714,940.00
Томилолт зочны зардал	745,200.00	200,000.00
Дотоод томилолт	745,200.00	200,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	33,929,328.79	36,806,947.54
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,263,400.00	8,948,700.00
Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	20,665,928.79	27,858,247.54
Бараа үйлчилгээний бусад зардал	268,597,448.13	220,535,790.28
Бараа үйлчилгээний бусад зардал	38,639,200.00	32,258,700.00
Хичээл, сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	21,487,900.00	0.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	208,470,348.13	188,277,090.28
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	121,876,290.69	153,242,280.00
Бусад урсгал шилжүүлэг	121,463,480.00	153,242,280.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	109,224,080.00	115,123,080.00
Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан алба хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	30,000.00	
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	12,201,400.00	38,119,200.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	412,810.69	-
Төвлөрүүлэх шилжүүлэг	412,810.69	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	1,222,677.51	14,258,424.35
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)		
Үнэ төлбөргүй гарсан зардал	0,00	0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	0.00	0.00
НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	1,222,677.51	14,258,424.35

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Хүснэгт 3. Өмч өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	282,116,816.00	384,449,705.89	1,195,233,364.90	1,861,799,886.79

2	Тайлант үеийн үр дүн			1,222,677.51	1,222,677.51
3	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	282,116,816.00	384,449,705.89	1,196,456,042.41	1,863,022,564.30
4	Тайлант үеийн үр дүн			14,258,424.35	14,258,424.35
5	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	282,116,816.00	384,449,705.89	1,210,714,466.76	1,877,280,988.65

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Хүснэгт 4. Мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,447,399,000.00	4,180,169,500.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,679,900.00	10,289,200.00
Нийтлэг татварын бус орлого	7,679,900.00	10,289,200.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого	7,679,900.00	10,289,200.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,469,900.00	9,299,200.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	210,000.00	990,000.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,469,719,100.00	4,169,880,300.00
Улсын төвлөрсөн төсвөөс	3,337,719,100.00	4,014,047,500.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,337,719,100.00	4,014,047,500.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	132,000,000.00	155,832,800.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	132,000,000.00	155,832,800.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	3,390,713,961.10	4,205,531,336.43
УРСГАЛ ЗАРДАЛ	3,390,713,961.10	4,205,531,336.43
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,281,982,181.10	4,041,230,416.43
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,582,126,057.53	3,149,782,885.89
Үндсэн цалин	1,621,488,988.99	1,851,643,390.83
Нэмэгдэл	841,877,318.39	1,039,087,856.54
Унаа хоолны хөнгөлөлт	-	100,667,677.32
Үр дүнгийн урамшуулал	118,759,750.15	158,383,961.20
Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	319,287,305.47	385,349,400.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	217,370,493.97	262,037,576.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	25,639,687.53	30,827,756.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	12,847,400.00	15,414,028.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	12,685,944.82	15,414,028.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	50,743,779.15	61,656,012.00
Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	121,587,189.31	142,832,800.00
Гэрэл цахилгааны зардал	18,000,000.00	31,500,000.00
Түлш, халаалтын зардал	100,000,000.00	110,832,800.00
Цэвэр, бохир усны зардал	3,587,189.31	500,000.00
Нормативт зардал	134,199,000.00	155,448,200.00
Хоол, хүнс	134,199,000.00	155,448,200.00
Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	13,000,000.00
Урсгал засвар	10,000,000.00	13,000,000.00

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,909,328.79	36,806,947.54
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	7,363,400.00	8,948,700.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	21,545,928.79	27,858,247.54
Бараа үйлчилгээний бусад зардал	85,873,300.00	158,010,183.00
Бараа үйлчилгээний бусад зардал	63,347,700.00	143,651,183.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	22,525,600.00	14,359,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	108,731,780.00	164,300,920.00
Бусад урсгал шилжүүлэг	108,731,780.00	164,300,920.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	96,530,380.00	126,181,720.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	12,201,400.00	38,119,200.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	86,685,038.90	(25,361,836.43)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	160,749,609.00	29,029,700.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	160,749,609.00	29,029,700.00
Дотоод эх үүсвэрээр	160,749,609.00	29,029,700.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	160,749,609.00	29,029,700.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(160,749,609.00)	(29,029,700.00)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(74,064,570.10)	(54,391,536.43)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	173,859,577.06	99,382,196.27
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	99,382,196.27	44,990,659.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хүснэгт 5. төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татаас, санхүүжилтийн орлого	4,368,519,500.00	4,279,551,696.27	88,967,803.73	98%
Улсын төсвөөс	4,102,867,800.00	4,014,047,500.00	88,820,300.00	98%
Орон нутгийн төсвөөс	155,832,800.00	155,832,800.00	0.00	100%
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	10,348,000.00	9,299,200.00	1,048,800.00	90%
Туслах үйл ажиллагааны орлого	885,000.00	990,000.00	-105,000.00	112%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	98,585,900.00	99,382,196.27		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,368,519,500.00	4,279,551,696.27	88,967,803.73	98%
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	4,368,519,500.00	4,234,561,036.43	133,958,463.57	96.9%
Ажиллагчидтай холбогдсон зардал	3,608,200,400.00	3,535,132,285.89	73,068,114.11	98%

Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	3,207,289,300.00	3,149,782,885.89	57,506,414.11	98%
Цалин	1,908,549,700.00	1,851,643,390.83	56,906,309.17	97%
Цалингийн тусгай нэмэгдлүүд	1,298,739,600.00	1,298,139,495.06	600,104.94	100%
Нийгмийн хамгааллын шимтгэл	400,911,100.00	385,349,400.00	15,561,700.00	96%
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	336,765,300.00	323,693,388.00	13,071,912.00	96%
Эрүүл мэндийн даатгалын хураамж	64,145,800.00	61,656,012.00	2,489,788.00	96%
Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал	142,832,800.00	142,832,800.00	0.00	100%
Гэрэл цахилгааны зардал	30,000,000.00	31,500,000.00	-1,500,000.00	105%
Түлш, халаалтын зардал	110,832,800.00	110,832,800.00	0.00	100%
Цэвэр, бохир усны зардал	2,000,000.00	500,000.00	1,500,000.00	25%
Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал	444,389,200.00	392,295,030.54	52,094,169.46	88%
Хоол	185,448,200.00	155,448,200.00	30,000,000.00	84%
Бусад бараа үйлчилгээний зардал	173,201,900.00	171,240,883.00	1,961,017.00	99%
Мэдээллийн технологийн зардал	46,511,000.00	27,858,247.54	18,652,752.46	60%
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	15,880,100.00	15,799,000.00	81,100.00	99%
Урсгал засварын зардал	13,000,000.00	13,000,000.00	0.00	100%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,348,000.00	8,948,700.00	1,399,300.00	86%
Урсгал шилжүүлэг	173097100.00	164300920.00	8,796,180.00	95%
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	134,977,900.00	126,181,720.00	8,796,180.00	93%
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	38,119,200.00	38,119,200.00	0.00	100%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		99,382,196.27	-99,382,196.27	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		44,990,659.84	-44,990,659.84	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 17,572.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 17,572.8 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайланд 17,572.8 мянган төгрөгийн зардлыг алдаатай тайлагнасан алдааг залруулсан.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар нийт 1,069,843.8 мянган мянган төгрөгийн зөрчил илэрснээс 5,740.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 1,064,103.0 мянган төгрөгийн зөрчилд зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт

1. Нэр бүхий 4 ажилтанд 487.8 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг тушаал шийдвэргүйгээр олгосон, 2 ажилтанд 5,263.0 мянган төгрөгийн цалинг ээлжийн амралтын олговортой давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, тус хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д ерөнхий нягтлан бодогч дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус зөрчсөн, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй тул төлбөрийн акт тогтоосон

3.2 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Төсвийн гүйцэтгэл, тайлагналтай холбоотой асуудал:

1.Илрүүлэлт:

Дотуур байранд стандартад заагдсанаас 1 тогооч илүү ажиллуулан 18,936.0 мянган төгрөгийг цалинд олгосон нь "Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээ" Ерөнхий шаардлага MNS 6781-2019 стандартыг зөрчсөн, ба “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

“Дотуур байранд стандартад заагдсанаас 1 тогооч илүү ажиллуулсан зөрчлийг арилгах, “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ” Ерөнхий шаардлага MNS 6781-2019 стандартыг мөрдөж ажиллах

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

2.Илрүүлэлт:

Удирдлагын багийн 7 гишүүний ажлыг дүгнэлгүйгээр оны эхэнд тушаал гарган жилийн турш 25,101.6 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 1-т "Төрийн үйлчилгээний албан хаагчийн ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвх санаачилгыг нь дэмжиж, үр бүтээлтэй ажиллуулах зорилгоор ур чадварын нэмэгдэл олгоход энэ журмыг мөрдөнө", Боловсрол шинжлэх ухааны сайдын, Хөдөлмөр нийгмийн ухааны сайдын, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35/А/10/ 1 тушаалаар батлагдсан "Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай" журмын 7-д “ Шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 60,0 болон түүнээс дээш хувийг хангасан багш, ажилтанд тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан ур чадварын нэмэгдэл олгоно.” гэж заасныг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Удирдлагын багийн 7 гишүүний ажлын үр дүнг Боловсрол шинжлэх ухааны сайдын, Хөдөлмөр нийгмийн ухааны сайдын, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35/А/10/ 1 тушаалаар батлагдсан "Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай" журамд заасны дагуу үнэлэн, ур чадварын нэмэгдэл олгож хэвших;

3.Илрүүлэлт:

Санхүүгийн байдлын тайлангийн авлагын эхний үлдэгдлийг бууруулах ажил зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заасныг тус тус зөрчсөн, “тасалбар болголт” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Авлага, өглөгийн эхний үлдэгдлийг бууруулах ажил зохион байгуулах;

Нийцлийн аудиттай холбоотой асуудал

4.Илрүүлэлт:

Шилэн дансны цахим системд батлагдсан төсвийг 912,078.5 мянган төгрөгөөр, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 99,200.6 мянган төгрөгөөр, тус тус дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1,1,6.1.6, 6.4.5-д заасан мэдээллийг энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ гэж заасныг зөрчсөн, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим системд батлагдсан төсөв, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ зэргийг үнэн зөв, бүрэн мэдээлэх; Эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэн, биелэлтийг 2026 оны 08 дугаар сарын 25 -ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд тус тус мэдээлж, баталгаажуулна уу. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Хүснэгт 6. Завсрын аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Санхүүгийн тайланг алдаатай илэрхийлсэн	1	165,278.2			1	165,278.2	1	165,278.2				

Хүснэгт 7. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн үр дүнгийн тайланг зардлыг алдаатай тайлагнасан	1	17,572.8			1	17,572.8	1	17,572.8				
Дүн	1	17,572.8			1	17,572.8	1	17,572.8				

Хүснэгт 8. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дотуур байрны 1 тогоочийг батлагдсан орон тооноос илүү ажиллуулсан	1	18,936.0					1	18,936.0
Удирдлагын багийн гишүүдийн ажлыг дүгнэлгүй оны эхэнд тушаал гарган үр чадварын нэмэгдэл олгосон /7 хүн/	1	25,101.6					1	25,101.6
Нэр бүхий 4 ажилтанд үр чадварын нэмэгдэл илүү тооцож олгосон .	1	487.8	1	487.8				
Нэр бүхий 2 ажилтанд цалин, ээлжийн амралтын олговрыг давхардуулан олгосон .	1	5,253.0	1	5,253.0				
Санхүүгийн байдлын тайлангийн авлагын эхний үлдэгдлийг бууруулах ажил зохион байгуулаагүй	1	8,786.3					1	8,786.3
Дүн	5	58,564.7	2	5,740.8			3	52,823.9

Хүснэгт 9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зерчлийн товч утга	Нийт зерчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зерчил илрээгүй								
Шилэн дансны цахим системд мэдээлэл дутуу мэдээлсэн	1	1,011,279.1					1	1,011,279.1
Дүн	1	1,011,279.1					1	1,011,279.1